



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/448

Мандалговь

Тусламж үзүүлэх тухай

“Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.17 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дэх заалт, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2021 оны 12 дугаар сарын 08-ний өдрийн 17 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сайхан-овоо сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч П.Эрдэнэбаатар асан нь албан үүргээ гүйцэтгэж яваад зуурдаар амь нас эрсдсэн тул түүний ар гэрт 1,000.000 (Нэг сая) төгрөгийн тусламж үзүүлсүгэй.

2. Тусламжид шаардагдах 1,000.000 (нэг сая) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), нягтлан бодогч (М.Янжиндолгор) нарт тус тус зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Ц.МӨНХБАТ

